



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 6/15

Ховд

Б.Батзаяаг ажилд томилох тухай


Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “Нэр дэвшүүлэх тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн захирлын албан тушаалд Бүрнээгийн Батзаяаг 2020 оны .05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТҮБД-5-2 дахь шатлал болох 893200 төгрөг /Найман зуун ерөн гурван мянга хоёр зуун/-өөр, Төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу үндсэн цалингийн 5 хувиар тус тус тооцож цалинжуулахыг тус сургуулийн нягтлан бодогч /Л.Минжмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Б.Батзаяад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 01232  
D/Zax-B/15-Da